

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2025/107/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2025 он	Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор: Э.Сүнжидмаа Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn Аудитор: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyam1202@gmail.com
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: (976) 70 48 34 13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2025. 02.24 № 91

танай _____ -ны № _____ -т

ТОНХИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Б.БАЯНЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Тонхил сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.7 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.1.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, үнэн зөв, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Сумын ИТХ-аар ЗДТГ-ын 2024 оны төсөвт сумын ой тэмдэглэх зардалд 50,000.0 мянган төгрөгийг баталсныг ойн урилга хэвлүүлэх, медаль, гарын бэлэг бэлтгэх, аж ахуйн болон хүнсний материал худалдан авахад 45,730.2 мянган төгрөг зарцуулсан;

8225020232

- Засаг даргын нөөц, хөрөнгөнөөс хүндэтгэлийн арга хэмжээнд 8,453.0 мянган төгрөг, баяр тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан бэлэг дурсгалын зүйл худалдан авахад 1,790.0 мянган, тушаал шийдвэргүйгээр 2,367.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан;
- Цалингийн зардлаас амралтын мөнгийг давхардуулан 274.8 мянган төгрөг олгосон, ажилтны 4,585.5 мянган төгрөгийн цалинг Нийгмийн даатгалын хэлтэст дутуу мэдээлсэн,
- Тоног төхөөрөмжийг бэлтгэхдээ цахим дэлгүүрээс 3,639.9 мянган төгрөгийн худалдан авалт хийгээгүй зэрэг 120,237.4 мянган төгрөгийн зөрчил илэрч, Байгууллагын дотоод хяналтгүйгээс бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд авлага, өглөг зөрүүтэй тусгасан, хөрөнгө орлого аваагүй, аймгийн ИТХ-ын тогтоолоор хөрөнгө акталсан байхад данснаас хасаагүй зэрэг нийт 441.778.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулсан.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд 100 жилийн ой тохиож орон нутгийн төсвөөс 100,000.0 мянган төгрөг олгосноос 42,954.0 мянган төгрөгийг гарын бэлэг, дурсгал худалдан авах, хүлээн авалт хийх, хоолны материал худалдан авахад тус тус үр ашиггүй зарцуулсан байна.

Иргэд, байгууллагаас 132,494.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө хандиваар, 396,548.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад эх үүсвэрээс шилжүүлэн авч, 325.0 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар хүлээн авч бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 61,467.5 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу авч, 65,459.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журмын дагуу шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэг олгох бүрэн эрхийг Засаг даргад олгосон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулиар дээрх арга хэмжээний зардлыг зарцуулахыг хориглосон байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 19,943.9 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 8,848.0 мянган төгрөгийг зарцуулж, 11,095.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Тайлант онд 1 хөтөлбөр, 4 зорилт, 75 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас хэрэгжүүлэн нийт дүнгээр 90.9 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Г.ГҮНЖИДМАА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>240,494,942.09</u>	<u>246,843,114.23</u>
33	АВЛАГА	17,518,921.09	13,667,093.23
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	603,508.13
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	6,563,585.10
335	Бусад авлага	17,518,921.09	6,500,000.00
33510	Байгууллагаас авах авлага	17,518,921.09	6,500,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	222,976,021.00	233,176,021.00
354	Хангамжийн материал	80,394,771.00	90,594,771.00
35410	Бичиг хэргийн материал	168,700.00	168,700.00
35420	Аж ахуйн материал	75,746,071.00	83,446,071.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,430,000.00	4,430,000.00
35470	Бусад хангамжийн материал	50,000.00	2,550,000.00
35600	Мал амьтад	142,581,250.00	142,581,250.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,090,800,984.88</u>	<u>2,382,218,691.58</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,090,800,984.88	2,382,218,691.58
392	Биет хөрөнгө	2,089,053,684.93	2,355,179,091.45
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,829,377,130.82	2,197,335,584.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	(645,702,672.58)	(734,604,535.24)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	312,311,775.00	304,290,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(139,728,092.37)	(120,725,555.72)
39205	Машин тонг төхөөрөмж (компьютер)	377,020,956.40	339,933,695.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(166,330,906.84)	(118,597,070.85)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,085,663.30	41,163,012.57
39208	Хуримтлагдсан элэгдэл	(36,238,465.08)	(19,051,321.01)
39214	Бусад үндсэн хөрөнгө	600,903,774.00	599,953,470.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(106,694,557.72)	(135,567,268.12)
39217	Ном	1,049,080.00	1,049,080.00
393	Биет бус хөрөнгө	1,747,299.95	27,039,600.13
39301	Програм хангамж	4,191,000.00	4,191,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,126,100.05)	(4,127,799.87)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,682,400.00	26,976,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,331,295,926.97</u>	<u>2,629,061,805.81</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	<u>7,930,050.91</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	7,930,050.91
413	Өглөг	-	7,930,050.91
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	498,318.00
4136	Бусад өглөг	-	7,431,732.91
41361	Байгууллагад төлөх өглөг	-	7,431,732.91
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,331,295,926.97</u>	<u>2,621,131,754.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,331,295,926.97	2,621,131,754.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	306,473,131.83	306,473,131.83
51101	Өмч: - төрийн	306,473,131.83	306,473,131.83
512	Хуримтлагдсан үр дүн	1,911,164,115.24	2,207,213,438.76
51210	Өмнөх үеийн үр дүн	1,877,707,269.78	1,917,377,610.83
51220	Тайлант үеийн үр дүн	33,456,845.46	289,835,827.93
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	113,658,679.90	107,445,184.31
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,331,295,926.97</u>	<u>2,629,061,805.81</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	887,543,020.00	1,649,635,218.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	190,900,000.00	529,367,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	190,900,000.00	529,367,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	166,400,000.00	529,042,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	24,500,000.00	325,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	696,643,020.00	1,120,268,218.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,774,120.00	168,359,818.09
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив	4,694,160.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,079,960.00	163,254,403.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,105,415.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,868,900.00	951,908,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн байгууллага/	585,868,900.00	951,908,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	854,086,174.54	1,357,152,990.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	854,086,174.54	1,345,830,490.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	836,829,973.02	1,250,083,569.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,491,761.73	540,489,818.50
210101	Үндсэн цалин	315,961,761.73	142,588,100.00
210102	Нэмэгдэл	-	379,000,000.00
210104	Урамшуулал	1,530,000.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	-	18,901,718.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,311,400.00	67,482,399.37
210201	Тэтгэврийн даатгал	25,691,800.00	46,052,002.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,904,900.00	5,391,918.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,323,900.00	2,756,669.85
210204	Ажилгүйдлийн даатгал	581,000.00	2,656,359.45
210205	Эрүүл мэндийн даатгал	5,809,800.00	10,625,449.34
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,368,697.66	67,625,903.25
210301	Гэрэл, цахилгаан	9,799,399.91	10,011,203.25
210302	Түлш, халаалт	60,569,297.75	57,614,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,085,060.00	53,794,895.00
210401	Бичиг хэрэг	2,469,850.00	4,958,050.00
210402	Тээвэр, шатахуун	29,135,850.00	30,431,100.00
210403	Шуудан, холбос, интернэтийн төлбөр	1,008,000.00	1,042,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,471,360.00	17,362,945.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,328,050.00	105,363,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	-
210604	Урсгал засвар	16,328,050.00	105,363,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,876,000.00	2,500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,876,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,676,244.00	88,699,277.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	35,676,244.00	87,814,909.09
210803	Даатгалын үйлчилгээ	-	278,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	96,188.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,692,759.63	324,128,175.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,325,200.00	44,629,708.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	430,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	232,367,559.63	279,068,467.85
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,256,201.52	95,746,921.65
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,290,000.00	30,287,590.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,442,106.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	18,860,484.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,290,000.00	1,985,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох санхүүжилт	14,966,201.52	65,459,331.65
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,966,201.52	65,459,331.65
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	11,322,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	11,322,500.00
223001	Бусад хөрөнгө	-	11,322,500.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	33,456,845.46	292,482,227.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,646,399.45
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,646,399.45
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,646,399.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	33,456,845.46	289,835,827.93

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	696,643,020.00	1,120,268,218.09
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	696,643,020.00	1,120,268,218.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,774,120.00	168,359,818.09
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,694,160.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,079,960.00	163,254,403.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,105,415.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	585,868,900.00	951,908,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн байгууллага/	585,868,900.00	951,908,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	663,183,020.00	1,089,805,798.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	663,183,020.00	1,089,805,798.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	628,407,897.39	987,495,291.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	314,485,545.73	521,588,100.00
210101	Үндсэн цалин	312,955,545.73	142,588,100.00
210102	Нэмэгдэл	-	379,000,000.00
210104	Урамшуулал	1,530,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,311,400.00	86,425,308.00
210201	Тэтгэврийн даатгал	25,691,800.00	64,265,308.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,904,900.00	5,540,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,323,900.00	2,770,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	581,000.00	2,770,000.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,809,800.00	11,080,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,368,697.66	67,625,903.25
210301	Гэрэл, цахилгаан	9,799,399.91	10,011,203.25
210302	Түлш, халаалт	60,569,297.75	57,614,700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,195,100.00	55,969,903.00
210401	Бичиг хэрэг	2,481,550.00	4,958,050.00
210402	Тээвэр, шатахуун	19,542,350.00	32,931,108.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,008,000.00	1,042,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,163,200.00	17,037,945.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,935,210.00	113,063,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	-
210604	Урсгал засвар	31,935,210.00	113,063,100.00
2107	Томилолт, зочны зардал	2,876,000.00	2,500,000.00
210702	Дотоод албан томилолт	2,876,000.00	2,500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	65,111,164.00	88,699,277.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	65,111,164.00	87,814,909.09
210803	Даатгалын үйлчилгээ	-	278,180.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	96,188.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	60,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	450,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	72,124,780.00	51,623,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	57,124,780.00	51,193,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,000,000.00	430,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,775,122.61	102,310,506.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,290,000.00	30,287,590.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,442,106.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	18,860,484.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,290,000.00	1,985,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	32,485,122.61	72,022,916.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	14,966,201.52	65,459,331.65
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	17,518,921.09	6,563,585.10
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,460,000.00	30,462,420.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	33,460,000.00	30,462,420.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	33,460,000.00	30,462,420.00
2200	Дотоод эх үүсвэрээр	33,460,000.00	30,462,420.00
223001	Бусад хөрөнгө	11,760,000.00	11,322,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	21,700,000.00	19,139,920.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(33,460,000.00)	(30,462,420.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	1,877,707,269.78	2,297,839,081.51
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	1,877,707,269.78	2,297,839,081.51
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	33,456,845.46	33,456,845.46
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	1,911,164,115.24	2,331,295,926.97
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	1,911,164,115.24	2,331,295,926.97
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	1,911,164,115.24	2,331,295,926.97
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	289,835,827.93	289,835,827.93
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	306,473,131.83	113,658,679.90	2,200,999,943.17	2,621,131,754.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,013,375,900.00	886,449,068.35	126,926,831.65	87.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	993,375,900.00	875,126,568.35	126,249,331.65	87.39
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	962,593,900.00	844,838,978.35	125,754,921.65	87.04
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	521,588,100.00	521,588,100.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	142,588,100.00	142,588,100.00	0.00	100.00
210102	Нэмэгдэл	379,000,000.00	379,000,000.00	0.00	100.00
210105	Гэрээт ажлын хөлс				
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,250,000.00	86,425,308.00	7,824,692.00	91.70
210201	Тэтгэврийн даатгал	72,090,000.00	64,265,308.00	7,824,692.00	89.15
210202	Тэтгэмжийн даатгал	5,540,000.00	5,540,000.00	0.00	100.00
210203	ҮОМШӨ-ий даатгал	2,770,000.00	2,770,000.00	0.00	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,770,000.00	2,770,000.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	11,080,000.00	11,080,000.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	125,791,900.00	66,330,487.35	60,961,412.65	52.11
210301	Гэрэл, цахилгаан	7,800,000.00	8,715,787.35	584,212.65	93.72
210302	Түлш, хаг аалт	117,991,900.00	57,614,700.00	60,377,200.00	48.83
2104	Хангамж, бараа материалын зардал	30,568,000.00	27,897,995.00	2,670,005.00	91.27
210401	Бичиг хэрэг	4,964,000.00	4,958,050.00	5,950.00	99.88
210402	Тээвэр, шатахуун	20,110,000.00	19,859,200.00	250,800.00	98.75
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,400,000.00	1,042,800.00	1,357,200.00	43.45
210404	Ном, хэвлэл	500,000.00		500,000.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	100,000.00		100,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,494,000.00	2,037,945.00	456,055.00	81.71
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,200,000.00	40,922,620.00	6,777,380.00	85.79
210601	Багаж, техник, хэрэгсэл	19,500,000.00	19,139,920.00	360,080.00	98.15
210604	Урсгал засвар	21,700,000.00	21,782,700.00	6,417,300.00	77.24
2107	Томилолт, зочны зардал	5,992,000.00	2,500,000.00	3,492,000.00	41.72
210702	Дотоод албан томилолт	5,992,000.00	2,500,000.00	3,492,000.00	41.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,760,000.00	47,550,768.00	5,209,232.00	90.13
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,500,000.00	46,666,400.00	4,833,600.00	90.61
210803	Даатгалын үйлчилгээ	650,000.00	278,180.00	371,820.00	42.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	96,188.00	3,812.00	96.19
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	60,000.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	450,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,443,900.00	51,623,700.00	38,820,200.00	57.08

Тонхил сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,943,900.00	51,193,700.00	38,750,200.00	56.92
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	430,000.00	70,000.00	86.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,782,000.00	30,287,590.00	494,410.00	98.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,782,000.00	30,287,590.00	494,410.00	98.39
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,582,000.00	9,442,106.00	139,894.00	98.54
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	18,900,000.00	18,860,484.00	39,516.00	99.79
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,300,000.00	1,985,000.00	315,000.00	86.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	20,000,000.00	11,322,500.00	6677,500.00	37.09
2200	Дотоод эх үүсвэрээр	20,000,000.00	11,322,500.00	6677,500.00	37.09
223001	Бусад хөрөнгө	20,000,000.00	11,322,500.00	6677,500.00	37.09
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,013,375,900.00	886,449,068.35	-126,926,831.65	87.47
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,013,375,900.00	886,449,068.35	-126,926,831.65	87.47
132001	Орон нутгийн төсвөөс	1,013,375,900.00	886,449,068.35	-126,926,831.65	87.47
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	28	24	4	-
620001	Удирдах ажилтан	8	8	-	-
620002	Гүйцэтгэх ажилтан	13	11	2	-
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	-
620004	Гэрээт ажилтан	4	2	2	-

2.6 Нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	110,774,120.00	168,359,818.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	110,774,120.00	168,359,818.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	93,255,198.91	161,796,224.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,930,000.00	-
210101	Үндсэн цалин	5,400,000.00	-
210104	Урамшуулал	1,530,000.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,973,988.91	1,295,415.90
210301	Гэрэл, цахилгаан	5,973,988.91	1,295,415.90
2104	Хангамж, бараа материалын зардал	10,200,700.00	28,071,900.00
210401	Бичиг хэрэг	210,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	4,247,500.00	13,071,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,743,200.00	15,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,280,510.00	91,280,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	-
210604	Урсгал засвар	12,280,510.00	91,280,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,870,000.00	41,148,509.09
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,870,000.00	41,148,509.09
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,518,921.09	6,563,593.10
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,518,921.09	6,563,593.10
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	17,518,921.09	6,563,593.10
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	110,774,120.00	168,359,818.09
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	110,774,120.00	168,359,818.09
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,694,160.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	106,079,960.00	163,254,403.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	5,105,415.00

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 441,778.7 мянган төгрөгийн 9 алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Залруулсан алдаа

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны өдрийн 28 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 392 нэрийг 250,102.0 мянган төгрөгийн балансын үнэ бүхий, өртгөө нөхсөн хөрөнгийг данснаас хасах шийдвэр гарсан ч тус байгууллага данснаас хасаагүй,
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 6,500.0 мянган төгрөгийг агнуур судлалын нийгэмлэгт "Агнуурын менежментийн төлөвлөгөөг шинэчлэх ажлыг гүйцэтгэх"-гэрээний дагуу төлж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тайланг хэлэлцээгүй байхад зардлаар бүртгэсэн,
- Сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардлаас худалдан авсан гэрэлтүүлгийн гэрлийн 7,700.0 мянган төгрөгийн хөрөнгийг бусад хангамжийн материалаас зарлага гаргасан,
- Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалтын Тамч багийн дамжин өнгөрөх өртөө 15,000.0 мянган төгрөг, Сур харвааны талбайн 19,900.0 мянган төгрөгийн гүйцэтгэсэн ажлыг санхүүгийн тайланд үндсэн хөрөнгийг давхардуулан 34,900.0 мянган төгрөгөөр орлого авсан,
- Нийтийн бие засах байгууламжийн ажлыг Хансан панзат ХХК 24,950.6 мянган төгрөгөөр гүйцэтгэж ашиглалтад оруулан хүлээлгэн өгсөн байхад тайланд орлогоор бүртгээгүй, үлдэгдэл 7,431.7 мянган төгрөгийн өглөгийг тайланд тусгаагүй,
- Нэмэлт санхүүжилтийн дансанд оны эцэст орсон малжуулах хөтөлбөр болон бусад арга хэмжээний үлдэгдэл 6563.6 мянган төгрөгийг төвлөрүүлснийг төрийн сантай тооцоо нийлж тайланд авлагаар тусгаагүй,
- Шагай харвааны хэрэгслийн 2500.0 мянган төгрөгийг шууд зардлаар бүртгэж, хөрөнгийг орлого аваагүй,
- Нэмэлт санхүүжилтийн харилцах дансанд буцаж орж ирсэн, андуурсан 2 гүйлгээний 92,719.6 мянган төгрөгийг нягтлан бодогч харилцах дансанд орлого, зардлыг бүртгэхдээ хоорондын тооцооны дансаар дамжуулан гүйлгээ бүртгэхгүй, байгууллагын орлогоор хүлэн зөвшөөрч мөнгөн гүйлгээ, үр дүнгийн тайланг буруу тайлагнасан,
- Төсвийн эдийн засгийн ангилал зөрчин цалингийн зардал, гэрээтийн цалингийн дутагдсан эх үүсвэрийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас гарган гүйлгээ хийснээс 10,651.0 мянган төгрөгийг үр дүнгийн тайланд зөрүүтэй тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн.

Залруулагдаагүй нийт 120,237.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их тул "Хязгаарлалттай" дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 120,237.4 мянган төгрөгийн 13 зөрчил² илэрч 4,432.3 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт, 115,162.6 мянган төгрөгийн 7 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага, 3 зөвлөмж хүргүүлсэн.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Төлбөрийн акт

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс тушаал шийдвэргүйгээр 2,367.5 мянган төгрөгийг Жаст Чандмань ХХК-д шилжүүлэн бэлэг худалдаж авахад зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15.1.7-т "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэсэн заалттай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2. Орон нутгийн нөөц хөрөнгөөс эмэгтэйчүүдийн баярыг тохиолдуулан 590.0 мянган төгрөгийн мөнгөн аяга, 1,200.0 мянган төгрөгөөр домбо худалдан авч төсвийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалттай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

3. Ажилчдын үндсэн цалинг амралтын цалинтай давхардуулан 1 ажилтанд 274.8 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Засаг даргын нөөц хөрөнгөөс хүндэтгэлийн арга хэмжээнд 8,453.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1-т "Төсвийн захирагч нөөц хөрөнгийн санхүүжилтийг зөвхөн зориулалтын дагуу зарцуулна" гэж заасантай нийцэхгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засаг даргын нөөц хөрөнгийг хүндэтгэл, хүлээн авалтын арга хэмжээнд зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Сумын 100 жилийн ойн арга хэмжээний зардлаас иргэнтэй сумын төвийн шавар гэрийн засварын ажил хийлгэхээр гэрээ байгуулан 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдөр 9,800.0 мянган төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон боловч ажлыг бүрэн хийлгээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр

худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", 41.2.7-т "хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах" гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээнд заасны дагуу ажлаа гүйцэтгээгүй, хүлээлгэн өгөөгүй байхад шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахгүй байгаа, алданги тооцоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Нийгмийн даатгалын хэлтэст 2 ажилтаны 4585.5 мянган төгрөгийн цалинг дутуу цалинг дутуу мэдээлж, тайлагнасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн ажилтнуудын цалинг нөхөн мэдээлж, цаашид давтан гаргуулахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Тайлант онд 3,639.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан аваагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно" "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Сумын 100 жилийн ойн арга хэмжээний дэмжлэгээс 17,975.0 мянган төгрөгийг ойн гарын бэлэг, дурсгал худалдан авахад, 6,688.5 мянган төгрөгийг хүнсний материалд, 3,216.0 мянган төгрөгийг өргөмжлөлд, 6,297.5 мянган төгрөгийг шатахуун, 3,000.0 мянган төгрөгийг хүлээн авалтын тоног төхөөрөмжийн түрээсийн зардалд, 1,277.0 мянган төгрөгийг хулдаасан хэвлэлийн зардалд, 4,500.0 мянган төгрөгийг тохижилттой өрх шалгаруулах шагналд, нийт 42,954.0 мянган төгрөгийг төгрөгийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", гэсэн заалтуудтай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг зарцуулахдаа зориулалтын дагуу зарцуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Тонхил сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Сумын 2024 оны төсөв батлах тухай" 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 27 дугаар тогтоолоор ЗДТГ-ын 2024 оны төсвийн зардалд оруулан сумын ой тэмдэглэх зардалд 50,000.0 мянган төгрөгийн баталж ойн урилга хийхэд 2,840.0 мянган төгрөг, медальд 4,405.5 мянган төгрөг, гарын бэлэг бэлтгэхэд 23,178.0 мянган төгрөг, анонас, стикер, өргөмжлөл хийхэд 1,892.3 мянган төгрөг, төрийн далбаа худалдан авахад 4,500.0 мянган төгрөгийг, аж ахуйн материалд 3,940.0 мянган төгрөгийг, урсгал зардалд 4,604.4 мянган төгрөгийг, хүнсний материал худалдан авахад 370.0 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана", 24 дүгээр зүйлийн 24.7-т "Төсвийн хөрөнгө, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд болон орон нутагт ногдох хөрөнгийг Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийтээр тэмдэглэх тэмдэглэлт өдөр, тэдгээртэй адилтгах аливаа өдөрлөгт зориулж зарцуулахыг хориглоно". Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах" гэсэн заалтуудтай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж буй зөрчлийг арилгаж цаашид давтан гаргуулахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

7. Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 67,777.5 мянган төгрөгийн 4, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 10,000.0 мянган төгрөгийн 1, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 30,139.5 мянган төгрөгийн 7 мэдээллийг байршуулаагүй, хуулийн хэрэгжилт 86.0 хувьтай байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-т "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" 6.4.4-т "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;" 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;" гэж заасантай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй, Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг нөхөн байршуулан зөрчлийг арилгаж, цаашид Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн иргэдэд ил тод бодитой, үнэн зөв мэдээллийг цаг хугацаанд нь хүргэж, зөрчлийг давтан гаргуулахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодогч бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ГАА-2025/107/НА-СТА-ТШЗ

1. Байгууллагын нярав өндөр настаны тэтгэвэрт гарсантай холбогдуулан амралтын мөнгөнд 1,433.8 мянга төгрөгийг урьдчилан бодож тооцсон дүнгээр бүрэн олгоод, дараа сарын тооцоонд оруулахгүй цалингийн программд мэдээллийг өгснөөс иргэнээс татвар, НДШ суутгаагүй, нягтлан бодогч НДХ-т цалинг мэдээлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах"; Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"; Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-т "суутгасан татварыг хуульд заасан хугацаанд харьяа татварын албанд үнэн зөв тайлагнах"; гэсэн заалтуудтай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалд дутуу мэдээлсэн цалинг нөхөн мэдээлж, ажиллагсдын мэдээллийг хүний нөөцийн программд бүрэн оруулан, сар бүр цалингийн программаар мэдээллээ шалгаж, цалин бодолт, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангийн дүнтэй тулгалт хийж баталгаажуулж, цаашид зөрчлийг давтан гаргуулахгүй байх.

2. Нэмэлт санхүүжилтийн дансанд 2023 онд төвлөрсөн аймгийн ОНХС-гийн хөрөнгө оруулалтын мөнгөнөөс сумын төвийн бохир усны нэгдсэн тоолуурын өрийг төлснөөс эх үүсвэр дутагдаж Хансан панзат ХХК-д тайлант онд 7,431.7 мянган төгрөгийн өртэй гарсан, мөн 2024 онд төсөвт дутуу тусгагдсан газрын төлбөр, авто машины төлбөрийн хураамжын зардлыг 642,5 мянган төгрөгийг нэмэлтийн орлогоос төлсөн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" гэсэн заалтуудтай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн дансанд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын мөнгийг зориулалтын дагуу зарцуулж, ажлыг бүрэн хүлээн авч, өрийг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

3. Байгууллагын дотоод хяналт хангалтгүйгээс бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй, цахимаар хийсэн цалингийн гүйлгээг баталгаажуулсан боловч цаасан суурьтай баримтын бүрдэлийг баталгаажуулаагүй, архивын стандартыг мөрдөж ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэсэн заалтуудтай нийцэхгүй "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын бүртгэл хөтлөлтөд тавих дотоод хяналтыг сайжруулан, бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулж, ажиллагсдын цалингийн цаасан суурьтай баримтыг архивын стандартын дагуу хэвлэн баталгаажуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Говь-Алтай аймгийн Тонхил сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тонхил сумын ЗДТГ	9	441,778.7	4	289,308.1	5	152,470.6	9	441,778.7				
Дүн	9	441,778.7	4	289,308.1	5	152,470.6	9	441,778.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тонхил сумын ЗДТГ	12	120,237.4	3	4,432.3	6	115,162.6	3	642.5	-	-	-	-
Дүн	12	120,237.4	3	4,432.3	6	115,162.6	3	642.5	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тонхил сумын ЗДТГ	1				1			
Дүн	1	-	-	-	1	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тонхил сумын ЗДТГ	-	-			-	-	-	-
Дүн	-	-			-	-	-	-
-Нийт дүн	1	-			1	-	-	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		

-----oOo-----